

2021 оны Сургуулийн Бонд



11-р сарын 2-ны Сонгуулийн өдөр, Арлингтоны сонгогчид сургуулийн дэд бүтцийг засаж, сайжруулах болон Арлингтон тойргийн сургуулийн сурагчдын тоо өсөн нэмэгдэж буйтай холбогдон гарах асуудлыг шийдэх зорилгоор гаргаж буй 23.01 сая долларын Сургуулийн бондыг батлах эсэх талаар саналаа өгөх юм. Сурагчдын улам бүр өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах, боловсролын чанарыг хангах, иргэдийн сургуулийн дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалтыг хамгаалах зорилгоор бид сургуулийнхаа барилгуудыг засан сайжруулсаар байгаа билээ.

2021 оны Сургуулийн бондоос гаргасан хөрөнгө Арлингтоны сургуулиудын хэрэгцээг хангахад хэрхэн туслах вэ?

2021 оны бондын хөрөнгө нь АТӨС-ийн сургуулиудын барилга байгууламжийг сайжруулах замаар сурагчдын хэрэгцээг хангах зорилгоор тодорхой хязгаартайгаар ашиглагдах болно. Энэхүү хөрөнгө оруулалт нь сурагчдын сурах хөгжих хэрэгцээг хангах эрүүд, бүх талын дэмжлэг бүхий сурагчдын орчныг бий болгоход туслах юм. Сургуулийн Зөвлөлөөс 2022-24 оны санхүүгийн жилийн Сургууль сайжруулалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд үүнд 156.71 сая долларын дэд бүтэц сайжруулалтын хөрөнгө багтсан юм.

Бонд хэрхэн үйлчилдэг вэ?

Хувь хүн болон гэр бүлийнхэн мөргөлийн зээл авдагтай адил бонд гэдэг нь томоохон хэмжээний засвар, сайжруулалтад хөрөнгө оруулахаар авсан, тодорхой тооны жилүүдэд хуваасан удаан хугацааны зээл юм. Урт хугацааны хөрөнгө оруулалт(тухайлбал сургуулийн барилга)-ыг бондоор төлөх нь одоогийн болон ирээдүйн татвар төлөгчдөд оногдох ачааллыг тэнцвэржүүлж, харин сургуульд хөрөнгө оруулалт хийснийхээ үр шимийг хүртэх боломж олгодог давуу талтай.


2021 оны Сургуулийн бондыг яаж ашиглах вэ?

23.01 сая долларын хөрөнгө оруулалт нь барилга байгууламж, аюулгүй байдлын төслүүдэд зарцуулагдах юм. Үүнд:

- **Дөрвөн сургууль** (Кемпбелл, Дрю, Рэндолф болон Свонсон) 2-ийн гал тогоог шинэчлэх. Сургуулийн үдийн хоолны хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэхийн тулд гал тогоог шинэчлэх ажилд хүнс хадгалах, бэлтгэх хэсэг болон хоолны заалыг сайжруулах ажил орно. Төсөв: 10,650,000 доллар
- **Өнөөдөр мөрдөж буй аюулгүй байдлын стандартад нийцүүлэхийн тулд** зургаан сургууль(Кемпбелл, Кенмор, Хоффман-Бостон, Лэнгстон, Лонг Бранч, Свонсон)-ийн нэвтрэх хаалга болон үүдний өрөөг засварлах. Ингэснээр гандаас ирэгсэд төв оффист бүртгүүлэх. Төсөв: 970,000 доллар
- **Heights Барилгын засварт** газар доорх зогсоол, Шрайверийн сурагчдын орц, гарцыг сайжруулах, гэрэлтүүлэгтэй зүлгэн талбайр бий болгох зэрэг орж байна. Төсөв: 11,390 доллар

АТӨС-н элсэлтийн хэмжээ ямар байх вэ?

АТӨС-д элсэгчдийн тоог урьдчилан тооцоолохдоо бодит болон таамагласан төрөлтийн тоо хэмжээ, барилга байгууламжийн ирээдүйн тооцоолол болон өнгөрсөн хугацаанд шилжсэн хүүхдийн тоо зэрэг зээр үндэслэдэг болно. АТӨС нь төлөвлөлт хийх зорилгоор ийм таамаглалыг арван жилийн хугацаагаар хийдэг. COVID-19 цар тахал сурагчдын элсэлтэд нөлөөгөө үзүүлээд байна. АТӨС-иудад элсэгчийн тоо 2020 оны намрыг 2019 оныхтой, өмнөх жилийн 2020-2021 оны таамаглалтай харьцуулахад маш ихээр буурсан ба.



Дараагийн бондуудад ямар арга хэмжээг санхүүжүүлэхээр байгаа вэ?

Арлингтоны Сургуулийн Зөвлөлийн 2022-2024 оны санхүүгийн жилийн Сургууль Сайжруулалтын төлөвлөгөөнд ирэх жилүүдэд санхүүжүүлэх нэмэлт хөтөлбөрүүд багтсан байна. Үүнд:

- Сургуулиуд дахь агааржуулалт, агаар шүүлтгийн системийг сайжруулахын тулд Агааржуулалтын Системийг сайжруулах. Шүүлтгийн системийг хамгийн дээд түвшин хүртэл сайжруулах. Томоохон хэсгүүдэд NEPA шүүлтүүртэй зөврийн агаар шүүлтүүр байрлуулах
- Нэмэлт сургуулиудын аюулгүй байдлыг хангахын тулд гал тогоо нэвтрэх хаалгыг засварлах
- Уэйкфильд, Вашингтон-Либерти, Уильямсбург, болон Йорктаун зэрэг сургуулиудын синтетик зүлгийг солих
- Арлингтоны Ажил Мэргэжлийн Төвийн Кампусын Төлөвлөлт
 - o Үе шат 1 – Арлингтоны Орон Нутгийн Ахлах сургуулийг шинэ газар луу нүүлгэх
 - o Үе шат 2 – Арлингтоны Ажил Мэргэжлийн Төвийн Кампусыг дараагийн шатанд шилжүүлэхээр төлөвлөх



2021 оны Сургуулийн Бонд

Өмнөх бондуудын хөрөнгөөр АТӨС-ийн ямар төслүүдийг хэрэгжүүлсэн бэ ?

Арлингтоны иргэдийн баталсан түрүүчийн бондууд нь ашиглаж буй барилгуудыг өргөтгөх болон шинээр дараах барилга байгууламж ашиглалтад оруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Үүнд:

- Шинээр 725-суудал бүхий Cardinal бага сургуулийг Reed Билдинг дээр нээх (2021 оны намар нээгдсэн)
- Боловсролын төвийг дахин төлөвлөх замаар 600 суудалтай ахлах сургууль нээх (2022 оны 1-р сар)
- Dorothy Hamm Дунд Сургуулийг засварлах болон өргөтгөх (2019 оны 9-р сард нээсэн; өргөтгөл нь 2020 оны 9-р сард ашиглалтад орсон)
- Н-В Woodlawn болон Шрайвер хөтөлбөрийг байрлуулах Heights Барилга (2019 оны 9-р сард ашиглалтад орсон)
- Alice W. Fleet Бага Сургуулийн Барилга (2019 оны 9-р сард ашиглалтад орсон)
- АТӨС-ийн гурван цогцолбор ахлах сургуулийн хүчин чадлыг нэмэхийг тулд дотоод засал хийх (дууссан)

АТӨС-ийн сургуулийн сайжруулалтын төлөвлөлтийн үйл явцад COVID-19 хэрхэн нөлөөлсөн бэ?

Энэ жил COVID-19 цар тахлаас шалтгаалан АТӨС-нд эдийн засгийн болон үйл ажиллагааны хүндрэлүүдийг туулаад байна. АТӨС нь 2022-2024 оны санхүүгийн жилийн Сургууль Сайжруулалтын Төлөвлөгөөнд баримтлах арга барилаа өөрчилж Сургууль Сайжруулалтын Төлөвлөгөөг Тойргийн захиргааны шийдвэрээр гурван жилээр батлахаар боллоо. Ердийн арван жилээр баталдаг Сургууль Сайжруулалтын Төлөвлөгөөнөөс ухарсан нь хязгаарлагдмал нөөцөө үр ашигтай хэрэглэх, хоёрдогч хүчин чадлын элсэлтийн өсөлтийг хадгалах болон ашиглаж буй тоног төхөөрөмж, байгууламийг сайжруулан, сурагчдын сурах, хөгжих боломжийг олгосон аюулгүй, эрүүл, хүүхдэд ээлтэй суралцах орчин бий болгох зэрэг боломжийг АТӨС-т олгох юм. Арлингтоны Сургуулийн Зөвлөл нь санхүүгийн хүндрэлтэй үед санхүүжилтийн өрсөлдөөнтэй хэрэгцээтэй тулгарч байгааг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд сургуулиудын хэрэгцээг хангахын тулд байгаа нөөц бололцоогоо аль болох үр дүнтэй хэрэглэхийн төлөө хамтран ажиллах боломжуудыг бид эрэлхийлэх болно.

АТӨС-өөс улам бүр өсөж буй элсэлтийн хэмжээ болон сургуулийн хүчийн чадлын асуудлыг шийдэх талаар Арлингтон Тойргийн засаг захиргаатай хэрхэн хамтарч байгаа вэ?

Сурагчдын суралцах үйл явцыг үр дүнтэй дэмжихийг сургуулийн нөхцлийг бий болгох зорилгыг хангахын тулд АТӨС нь гурван А (AAA) зэрэглэлийн бондыг гаргахаар Арлингтон Тойрогтой нягт хамтран ажиллаж байна. Түүнчлэн АТӨС-өөс зөвлөх хороодтой нягт хямтран ажиллаж байгаа бөгөөд Арлингтон Тойргийн томоохон хэмжээний бүтээн байгуулалтуудын ирээдүйн хэрэгцээг судалж, хангахад нэгдмэл арга барил ашиглаж байна.

Сургуулийн бондууд хүүхэд нь сурдаг Арлингтоны иргэдтэй хэрхэн хамаарах вэ?

Хэдийгээр бүх оршин суугч сургуулийн насны хүүхэдгүй ч тэдгээрт АТӨС-ийг хүүхэд нь төгссөн эсвэл хүүхдээ ирээдүйд сургахаар бэлдэж буй эцэг эх, гэр бүлүүд багтдаг. Сургуулиа чадавхжуулах ажилд хөрөнгөр оруулснаар хүн бүхэн ач тусыг нь дараах хоёр замаар хүртэх болно.

1. **АТӨС-ийн барилга байгууламжийг иргэд ашиглах** – АТӨС-ийн байрыг Арлингтоны иргэд жилдээ 58000 гаруй цаг ашигладаг бөгөөд үүнд усан сан ашиглах Арлингтон Тойргийн Соёл Амралтын Хүрээлэнгээс явуулдаг амралтын өдрүүдийн хөтөлбөр явуулах, хичээл сургууль хаагдсан үед сургуулийн байранд зуны сургууль явуулах, олон төрлийн үзэсгэлэн худалдаа, урлаг соёлын арг ахэмжээ, тусгай хуралдаануудыг явуулах зэрэг ордог.
2. **Эдийн засгийн нөлөөлөл** – Сургуулийн үйл ажиллагааны санхүүжилт нь ажлын байр бий болгох үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, Арлингтон дахь томоохон компаниудыг татах зэрэг давуу талыг авчирдаг. АТӨС-н Сургууль Сайжруулалтын Хөтөлбөрт зарцуулсан нэг сая доллар бүрт 10.4 ажлын байр бий болгох үйл явцтай холбоотой байсныг судалгаа харуулсан байна. АТӨС-н сурагчдын сурлагын чанар сайжирсан болон сургуулиудын рэйтинг өссөн зэрэг нь Арлингтоны үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг өсгөж, үл хөдлөх хөрөнгийн татвараас орох орлогыг нь нэмжээ. Саявтархан манай сургуулийн системд Nestlé болон Amazon зэрэг томоохон компаниуд татагдан ороод байна. Уг хоёр компани хоёулаа Арлингтонд төв оффисоо байгуулахад сургуулиудын чанар нөлөөлсөн хэмээн үзсэн байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл хаанаас авч болох вэ?

2021 оны сургуулийн бонд болон бүх 2022-2024 оны санхүүгийн жилд төлөвлөсөн бүх төсөл хөтөлбөрүүдийг www.apsva.us/CIP. үзнэ үү.

2021 оны Сургуулийн бондыг би яаж дэмжиж болох вэ?

Сургуулийн бондын талаарх санал хураалт 2021 оны 11-р сарын 2-ны өдөр явагдана. Санал өгөх гурван арга зам бий:

- Саналаа эрг өгөөрэй: 2021 оны 9-р сарын 17-ноос эхлэн Арлингтон дахь таван газраас сонголтгоо хийгээрэй.
- Шуудангаар: 2021 оны 10-р сарын 21 гэхэд саналын хуудсаа авах ёстой.
- Биечлэн: Сонгуулийн цэгт— 2021 оны 11-р сарын 2-ны 6 а.м.-7 р.м хүртэл нээлттэй.

Сонгуулийн цэгийн байршлыг мэдэх эсвэл санал өгөх хуудас авах бол vote.arlingtonva.us хуудсаар зочлоорой.